



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г  
Т  
Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний  
chanar хүrtээмжийг нэмэгдүүлэх,  
ажилтнуудын сахилга, хариуцлагыг  
сайжруулах тухай

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний chanar, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, эрүүл мэндийн удирдах, гүйцэтгэх ажилтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор дараах албан даалгаврыг өгч байна:

Нэг. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагын дарга, захирал нарт:

1.1 “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, “Төрийн албанад ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 02 дугаар зөвлөмжийг биелүүлэх;

1.2 Эрүүл мэндийн байгууллага өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулах, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас төрийн бүх шатны байгууллагад тавьсан өргөдөл гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, ил тод мэдээлж байх;

1.3 Байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал, шударга бус байдал гаргахгүй байх талаар соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

1.4 Байгууллагын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо”-ны үйл ажиллагааг эрчимжүүлж, эмч, эмнэлгийн ажилтнуудад төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлэх, удирдах ажилтнууд өөрсдөө ёс зүйн манлайлал үзүүлэх;

143220041

1.5 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал болон дотоод хяналтын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, тусlamж, үйлчилгээний чанар, үйлчүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой стандарт, дүрэм, журам, удирдамж, зааврыг эрүүл мэндийн ажилтнуудад тухай бүр танилцуулан чанд мөрдүүлэх, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулах;

1.6 Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн байгууллагад дархлаажуулалттай холбоотой асуудлаар гарсан алдаа зөрчлийг давтахгүй байхыг холбогдох албан тушаалтнуудад анхааруулж, эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, хаягжилт, хугацаа, хадгалалт, хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах;

1.7 Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйтэй холбоотой асуудлаар гарсан алдаа дутагдал, хууль тогтоомж зөрчсөн үйл ажиллагааг нуун дарагдуулахгүйгээр тухай бүрт хариуцлага тооцож, ил тод мэдээлж байх;

1.8 Төсвийн шууд захирагч нар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, үр ашиггүй зардал гаргахгүй байх, шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэд байршуулж хэвших;

1.9 Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг иргэдэд ээлтэй зохион байгуулах талаар шинэлэг санаачлага гаргаж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, байгууллагын үйлчилгээний соёл, ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах;

1.10 Иргэнд эмнэлгийн яаралтай тусlamжийг харьяалал харгалзахгүй үзүүлж, эмнэлгийн орц, гарцыг түргэн тусlamжийн болон үйлчлүүлэгчийн автомашин нэвтрэхээр чөлөөтэй болгох, Хүлээн авах, Яаралтай тусlamжийн хэсгийг тод харагдахуйц, орой, шөнийн цагаар гэрэлтүүлэг бүхий хаяг, тэмдэг, тэмдэглэгээтэй болгох;

1.11 Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг тогтвортсоон суурьшилтай ажиллуулахад анхаарч, хууль бус халаа, сэлгээ, томилгоо хийхгүй байх.

Хоёр. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэнд:

2.1 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах зорилгоор санхүүжилтийг бүрэн олгох нөхцөл бүрдүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах;

2.2 Эрүүл мэндийн байгууллагад олгох тусlamж, үйлчилгээний санхүүжилтийг “Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 13 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн тухайн байгууллагатай байгуулсан гэрээнд заасан цаг хугацаанд нь олгож байх;

Гурав. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаад:

3.1 Улсын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн байдалд тогтмол хяналт тавьж, эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал, хомдол үүсэхээс сэргийлж, нөөц бүрдүүлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;

3.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, тасалдал, эмийн үнэд үзүүлж байгаа хөнгөлөлтийн талаар иргэдээс гаргаж байгаа санал, гомдол, шүүмжлэлийг судлан дүгнэлт гаргах, мэдээлэх, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг шуурхай шийдвэрлэх;

3.3 Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэнээс эм тариа, эмнэлгийн хэрэгслийг давхардуулан гаргуулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, зөрчлийг таслан зогсоох бүх талын арга хэмжээг авч ажиллах.

Дөрөв. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т хариуцуулж, биелэлтийг Эрүүл мэндийн сайдад улирал тутам танилцуупахыг даалгаж байна.

